



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 09 сарын 29 өдөр

Дугаар А/517

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 4/03 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын хэмжээнд ковид-19 вирусийн халдвар тархсантай холбоотой аймгийн Онцгой комиссын шийдвэрийн дагуу 2021 оны 05 дугаар сарын эхний 10 хоногт дулаанаар хангагдсан орон нутгийн төсвийн байгууллагуудын халаалтын зардалд 49 385 000 төгрөгийг хавсралтад дурдсанаар зарцуулсугай.

2. Тус арга хэмжээнд зарцуулах 49 385 000 төгрөг /дөчин есөн сая гурван зуун наян таван мянга/-ийг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 4 дүгээр хуралдааны 4/03 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан аймгийн орон нутгийн хөрөнгөөр 2021 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт хөтөлбөр арга хэмжээний жагсаалтын 2.6 дахь заалтаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/, Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга /Б.Баярсүх/ нарт зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч /Т.Жаргалсайхан/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

Аймгийн Засаг даргын 2021 оны
09 дүгээр сарын 29-ний өдрийн
А/517 дугаар захирамжийн хавсралт

ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГУУДЫН ХАЛААЛТЫН ЗАРДЛЫН ТООЦОО

Д/д	Байгууллагын нэр	Мөнгөн дүн
1	4-р цэцэрлэг	1 641 400
2	Цаст-Алтай цогцолбор сургууль	11 954 900
3	12 жилийн 2-р сургууль	8 514 000
4	7-р цэцэрлэг	1 424 600
5	Хөгжимт драмын театр	4 187 700
6	12 жилийн 1-р сургууль	8 372 400
7	16-р цэцэрлэг	3 553 500
8	Хүүхэд, гэр бүл, залуучуудын хөгжлийн газар	6 146 900
9	11-р цэцэрлэг	1 682 000
10	Музей	1 543 400
11	Номын өргөө	363 800
	НИЙТ	49 385 000

-oOo-